



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/51

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хүчингүй  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.4, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.2, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны №04/41 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гэрээнд заасны дагуу газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй Эрдэнэс монгол ХХК-ийн Шинэ усны хэсгийн талбайн ашигт малтмал ашиглах зориулалтаар эзэмшүүлсэн 4293 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь хүчингүй болгосныг Эрдэнэс монгол ХХК-д мэдэгдэж, холбогдох бичиг баримтыг хүлээж авахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны А/98 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ